



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 3/а

Баян-Овоо сум

Н.Түмэн-Өлзийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсэг, Төсөвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоол (төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай) 7,11 дүгээр хавсралт, 84 дүгээр тогтоолын 2,3 дугаар хавсралт (тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай), 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолын 1, 5, 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүлгийн багшаар ажиллаж байсан Намсрайжавын Түмэн-Өлзий нь жирэмсэн амаржсаны амралт дуусаж үүрэгт ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн бага бүлгийн багшийн үндсэн ажилд нь үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.Ажил хүлээлцэх комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Энхжаргал	арга зүйч
Гишүүдэд:	Н.Ундармаа	багшийн туслах
	Ч.Сарангуа	нярав

3.Н.Түмэн-Өлзийгийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комиссын дарга (М.Энхжаргал)-д даалгасугай.

4.Н.Түмэн-Өлзийг ТҮБД-4 шатлалаар буюу 1559000 (нэг сая таван зуун тавин есөн мянган) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, заах аргач мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

5. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Түмэн-Өлзийд үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ Ц.ЭНХМАА

